



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/112

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Худалдааны гудамж-1-124 тоот)-т байршилтай Сайнхүү овогтой Батсүх (ЗИ:92063014)-ын худалдаа, үйлчилгээний зориулалттай 217 м.кв (0,02га) газрыг Пүрэвдорж овогтой Сүрэнжаргал (ЗК:74100206)-д зориулалтаар нь шилжүүлж 23 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/330 дугаар захирамжийн иргэн С.Батсүх-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000025695 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010324